

МОНГОЛБАНКНЫ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН МЭДЭЭЛЭЛ

Монголбанкны Хяналтын зөвлөлийн ээлжит хурал 2014 оны 9 дүгээр сарын 22-нд болов. Тус хурлаар Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албанаас мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар хийж буй ажлын явц, үр дүнгийн талаар тус албаны дарга Б.Төмөрбатын мэдээлэл, Монголбанкны дотоод хяналтын болон санхүүгийн тайлан гаргах эрх зүйн орчинг боловсронгуй болгох, дотоод хяналтын үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөө, тэдгээрийн хэрэгжилтийн явц, үр дүнтэй танилцсан Хяналтын зөвлөлийн гишүүн Ч.Энхбаатарын мэдээлэл зэргийг хэлэлцэв.

Хэлэлцсэн асуудалтай холбогдуулан гаргасан Монголбанкны Хяналтын зөвлөлийн шийдвэрийг Монголбанкны Ерөнхийлөгчид хүргүүлж, УИХ-ын байнгын хороонд явуулахаар тогтов.

МОНГОЛБАНКНЫ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ